



СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНДЭСНИЙ ТӨВ
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2016 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 07

Улаанбаатар

Сахилга хариуцлага, ажлын цаг ашиглалтыг сайжруулах тухай.

Тус ТӨҮГ-ын захирлаас Төрийн өмчийн хороотой байгуулсан гэрээний 37 дугаар заалт, захирлын зөвлөлийн 2015 оны 01 дүгээр сарын 04-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын хэмжээнд хөдөлмөрийн сахилга, ажлын хариуцлагыг сайжруулах, дотоод журмыг чанд баримтлах, 2016 онд байгууллагын өмнө тавигдсан зорилт, бизнес төлөвлөгөөг ханган биелүүлэхэд идэвхи санаачлага гарган ажиллахыг нийт ажилчдад үүрэг болгосугай.
2. Ажилтнуудын ажлын ачаалал, хариуцсан ажлынх нь явц байдалд үнэлэлт дүгнэлт өгч ажлын байрны тодорхойлолт болон ажилтан бүрийн ажил үүргийн хуваарийг шинэчлэн боловсруулж, мэргэжлийн болон арга зүйн зөвлөмж, удирдлагаар хангаж тэдний ажлын цаг ашиглалтыг сайжруулж ажиллахыг алба болон хэлтсийн дарга нарт даалгасугай.
3. Байгууллагын дотоод дэг журам, харуул хамгаалалтын үүрэг хариуцлага сонор сэрэмжийг чангатгах үүднээс тодорхой журам гаргах, ажилтнуудын ажлын цаг бүртгэл, цаг ашиглалтад тавих хяналтыг тогтмолжуулж гарсан аливаа зөрчил дутагдлыг тухай бүрт нь арилгах арга хэмжээ авч ажиллахыг алба хэлтсийн дарга / Ч.Батболд, Т.Батзаяа, М.Хоролсүрэн / нарт үүрэг болгосугай.
4. Сахилга, дэг журам, ажлын хариуцлагыг өндөржүүлэх талаар одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомж бусад эрх зүйн актыг судлан энэ чиглэлээр байгууллагын дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулан захирлын зөвлөл болон хамт олны хурлаар хэлэлцүүлэхийг хүний нөөцийн мэргэжилтэн Б.Халиунаад даалгасугай.